

Монгол хэлний эерэг сэтгэл хөдлөл илэрхийлсэн үүсмэл үйл үгийн судалгаа

Хулангийн Лхагвабаяр 
“Монгол коосэн” Технологийн коллежийн Ерөнхий эрдмийн тэнхимийн багш, доктор (Ph. D),
Монгол улс, Улаанбаатар.

Хүлээн авсан - Received:
2025-03-25

Засварласан - Revised:
2025-05-19

Хэвлэгдсэн - Published:
2025-06-19

Lkhagvabayar.kh@mk.edu.mn

ORCID: [0009-0006-5721-1118](https://orcid.org/0009-0006-5721-1118)



© 2025, Author(s)

Хураангуй: Тус өгүүлэлд “Монгол хэлний их тайлбар толь” (2016) бичгээс бүртгэж авсан нийт 117 үгийг “Баярлах, Тэсвэр тэвчээртэй байх, Тайван байх” сэтгэл хөдлөлтэй холбоотой үйл үгийн бүтэх арга хэмээн утгын зүйлчлэлээр нь ангилсан бөгөөд тухайн үүсмэл үйл үгс ямар ямар дагаврын аргаар, хэрхэн бүтсэн зүй тогтлыг онолын суурь судалгаанд тулгуурлан тодорхойлов. Ингэхдээ үр дүнгийн хэсэгт судалгааны үндсэн агуулгыг 1. Баярлах сэтгэл хөдлөлтэй холбоотой монгол хэлний үйл үг бүтэх арга; 2. Тэсвэр тэвчээртэй байх сэтгэл хөдлөлтэй холбоотой монгол хэлний үйл үг бүтэх арга; 3. Тайван байх сэтгэл хөдлөлтэй холбоотой монгол хэлний үйл үг бүтэх арга хэмээн 3 хэсэгт авч үзэв.

Аль ч хэлний үгийн санд сэтгэл хөдлөл илэрхийлсэн үг хэллэг байх ба тухайн үндэстний соёл, амьдралын хэв маяг, ёс заншил, сэтгэлгээний онцлогоос хамаараад тоо хэмжээний хувьд харилцан адилгүй байдаг. Бидний судалгааны ажил нь монгол хэлний эерэг сэтгэл хөдлөл илэрхийлсэн үйл үгийн хүрээнд хамрах ба эдгээр үг хэллэгийг холбогдох эх хэрэглэгдэхүүнээс бүртгэн авч, үгсийн

аймаг, үг зүйн талаас нь судалж, тухайн үйл үгсийн бүтэх аргын талаар тодруулахыг зорив. Түүвэрлэн авсан 117 үгнээс 88 нь дагаврын аргаар бүтжээ. Үүнд “-д, -ж, -л, -р, -рх, -с, -т, -ш, -шаа” зэрэг 9 дагавар бүртгэгдсэн байна. Өөрөөр хэлбэл, дээрх 9 дагаврын аргаар эерэг сэтгэл хөдлөл илэрхийлсэн нийт 88 шинэ үүсмэл үйл үг бүтжээ гэж ойлгож болно. Эдгээрээс хамгийн бүтээлч нь “-л”, “-р” дагавар байв. Энэ нь хэл шинжлэлийн эрдэмтдийн дэвшүүлсэн дүгнэлтдээ нийцэж байна. Хэлний хичээл зааж буй багш нар тухайн хэлний үгийн язгуур, үндэс, дагавар, нөхцөл болон уг үгийн хэрхэн үүссэн зүй тогтлыг сайтар ойлгож, суралцагчдад үгийн гарал болон язгуур, үүр нэгтэй үгийн талаар тайлбарлан таниулахад чухал ач холбогдолтой.

Түлхүүр үг: Үгсийн сан, үг бүтэх ёс, шинэ үг, үйл үгийн утга, хэлний хэрэглээ

1. ОРШИЛ

Юуны өмнө бидний судлахаар зорьж буй уг сэдвийн хүрээнд монгол хэлээр төдийлөн дагнасан судалгаа хийгдээгүй байгаа бөгөөд энэ талаар ихэнх судлаачид өөрсдийн судалгааны бүтээлдээ дам, давхар дурдсан төдийгөөр хязгаарлагдаж байгаа юм. Бидний судалгааны ажилд авч хэрэглэсэн үгийн тоо цөөн боловч тухайн бүрдүүлсэн материал дээр тулгуурлан, үгсийн аймгаар ангилж, үг бүтэх ёсны талаас нь зохих хэмжээнд тодорхойлохыг хичээв.

Ер нь сэтгэл хөдлөл илэрхийлсэн үгсийн утга, хэрэглээ, тэдгээр үгсийн бүтсэн зүй тогтлыг судлах нь амьд харилцаа үгүйлэгдэж буй өнөөгийн нийгэмд чухал ач холбогдолтой судлахуун болох нь дамжиггүй. Сүүлийн жилүүдэд хүний сэтгэл зүй, түүнтэй холбоотой сэтгэлзүйн стрессээс гарах арга зам, стресс менежментийн ур чадварыг ирээдүйд эрэлттэй хэмээн үзэж, тэр дундаа боловсролын салбарт бие хүнд шаардлагатай soft skill буюу зөөлөн ур чадварын жагсаалтад зүй ёсоор оруулдаг. Мөн эерэг үг хэллэг нь хүний сэтгэл санааг өргөөд зогсохгүй зарим амин бодист ч нөлөөгөө үзүүлж буй талаар сүүлийн үеийн дэлхий нийтэд явуулж буй туршилт, судалгаа харуулсаар байна. Тухайлбал, Японы эрдэмтэн, доктор Масару Эмото 23 жилийн турш усыг судалж, улмаар ус сайн муу мэдээллийг авах бүрд талст нь өөрчлөгддөг гэдгийг шинжлэх ухааны үндэстэйгээр гаргасан ажээ. Өөрөөр хэлбэл, “ус бол амьд, баярлаж, гомдож, эргэн тойрныхоо эерэг, сөрөг мэдээллийг агуулдаг” гэдгийг баталжээ. Доктор Масару Эмото “Нэг дэлхий эв нэгдэл клуб” төрийн бус байгууллагын урилгаар монголд анх удаа хүрэлцэн ирсэн бөгөөд “Хариулт нь усанд буй” лекцээ олон нийтэд танилцуулжээ Хэн бүхний анхаарал татахуйц энэ мэт судалгааны бүтээлүүд ар араасаа гарч буй нь эерэг сэтгэл хөдлөл илэрхийлсэн үг нь зөвхөн хүнд бус хүрээлэн буй амин бодист ч нөлөөгөө үзүүлдэг гэдгийг баталж буй мэт.

Сэтгэлийн хөдөлгөөн нь хүний амьдрал, үйл ажиллагааны үр бүтээлийг дээшлүүлж, хүний танин мэдэх болон бие бялдар, оюун санааны эрчим хүчийг өрнүүлж байвал тэр нь идэвхтэй сэтгэлийн буюу эерэг сэтгэлийн хөдөлгөөн юм (Өнөрбаян, 2000). Ж нь: *баярлаж догдлох, инээж хөөрөх, хайрлаж дурлах, хүсэж тэмүүлэх* гэх мэт.

Эерэг сэтгэл хөдлөл илэрхийлсэн үгсийн талаарх олон улсын судалгааг авч үзвэл, солонгост: эрдэмтэн Им Жи Рён (1995, 1997, 1999, 2006) Солонгос хэлний сэтгэл хөдлөлийн цогц ойлголтын төлөв байдлын судалгааг өргөн хүрээнд судалжээ. Мөн Хань Инь-Хуа (2017) “Монгол, солонгос хэлэнд сэтгэл хөдлөлийг илэрхийлэх онцлог, танихуйн утга”-ын талаар судлахдаа монгол, солонгос хэлний сэтгэл хөдлөлийн илэрхийллийг танихуйн хэл шинжлэлийн хүрээнд шинжлэн судалж, хоёр ард түмний соёл, сэтгэлгээний онцлогийг тодорхойлсон нь чухал ач холбогдолтой судалгаа болжээ. Түүнчлэн Ким Хян Сүг (2001, 2003) “Солонгос хэлний сэтгэл хөдлөл илэрхийлсэн хэлц үгийн судалгаа”, И Сү Сан “Солонгос хэлний сэтгэл хөдлөлийн үгсийн утгын хамаарал, ангиллын шинжилгээний судалгаа” зэрэг судалгааг дурдаж болно (Ариунчимэг, 2023).

Япон гаралтай канадын судлаач, Калгарийн Их сургуулийн сэтгэл судлалын тэнхимийн докторант Эмико Мураки, канадын судлаач тус сургуулийн профессор Пэнни Пэксман нарын хамтарсан (Pexman, 2024) “The role of emotion in acquisition of verb meaning” хэмээх судалгаа байдаг ба эдгээр судлаачид үйл үгийн утга ойлголтод сэтгэл хөдлөлийн үүргийг судалсан байна. Тус судалгаанд хэлний утгыг ойлгоход мэдрэхүйн болон хөдөлгөөний төсөөлөл хэрхэн нөлөөлдийг түлхүү тусгажээ.

Мөн АНУ-ын Алабамагийн Их сургуулийн сэтгэл судлалын тэнхимийн профессор Виллиам Харт “Unlocking past emotion: verb use affects mood and happiness” өгүүлэлдээ: үйл үгийн хэлбэр нь тухайн үеийн сэтгэл санаа, аз жаргалд хэрхэн нөлөөлдөг талаар судалгаа хийжээ (Hart, 2013). Харамсалтай нь уг судалгааг “Psychological Science” сэтгүүлийн газраас судалгааны мэдээлэлд эргэлзээтэй зүйл байгаа талаар тэмдэглээд цаашид судалгааны эргэлтэд оруулах боломжгүй хэмээн санал буцаан татжээ. АНУ-ын Вермонтын Их сургуулийн компьютер шинжлэлийн хүрээлэнгийн профессор Питер Шеридан Доддс (2014) “Human language reveals a universal positivity bias” судалгаанд хэлний хэрэглээнд эерэг сэтгэл хөдлөлийн хандлага нийтлэг байдаг талаарх алгоритм хэмжилтийн судалгааг хийжээ.

Харин эерэг сэтгэл хөдлөл илэрхийлсэн үгсийг утгын талаас нь ангилал хийж, энэ талын судалгааг өргөн цар хүрээнд судалсан хүмүүс бол АНУ-ын нэрт судлаачид Ж.Рассел (1977, 1980), Р.Тэйер

(1989, 2001), Д.Ватсон, А.Кларк (1988), Б.Фредриксон (2001), Р.Плучик (2001) нар юм (Ариунчимэг, 2023). Өөрөөр хэлбэл, энэ чиглэлийн судалгааг америкийн эрдэмтэд шинэ шатанд гаргаж, өргөн хүрээнд судалсан гэж хэлж болно.

Монголд П. Одончимэг (2008) “Монгол болон солонгос хэлний сэтгэл хөдлөлийн илэрхийллийн утга, орчуулах судалгаа” сэдэвт магистрын зэрэг горилсон бүтээлдээ монгол, солонгос хэлний сэтгэл хөдлөлийн илэрхийлэл, тэдгээрийн утга, орчуулгын асуудлыг хөндөж, харьцуулан хийжээ. Мөн магистр А. Ариунчимэг (2023) “Хүний эерэг сэтгэл хөдлөлтэй холбоотой солонгос, монгол үг хэллэгийн утгын харьцуулсан судалгаа” (үйл үг, тэмдэг үйл үгийн жишээгээр) сэдэвт магистрын судалгааны ажил бичиж, амжилттай хамгаалсан нь үгийн сан-утга зүй, утга судлалд хамаарах бол, бидний өгүүлэл монгол хэлний эерэг сэтгэл хөдлөл илэрхийлсэн үүсмэл үгийн судалгаа буюу үг зүйн судлалд хамаарна.

Тус судалгааны ажил цаашид хэл шинжлэлийн болон нийгмийн бусад хүрээнд тодорхой хэмжээний судалгааны хэрэглэгдэхүүн болно гэдэгт итгэж байна.

Тус судалгааны ажлын гол зорилго нь монгол хэлэн дэх эерэг сэтгэл хөдлөлтэй холбоотой үгсийг холбогдох эх хэрэглэгдэхүүнээс түүвэрлэж, утгын зүйлчлэл болон үүсмэл үйл үгийн дагаврыг байраар нь ангилан, үг зүйн талаас нь судалж, үг бүтэх ёсны онцлог талыг тодорхойлоход оршино. Үүний тулд дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

- Монгол хэлний эерэг сэтгэл хөдлөлтэй холбоотой үгсийг бүртгэн, утгын зүйлчлэлээр нь ангилах
- Монгол хэлний эерэг сэтгэл хөдлөлтэй холбоотой үгсийн үг бүтэх аргыг тодорхойлох
- Монгол хэлний эерэг сэтгэл хөдлөлтэй холбоотой үүсмэл үйл үгийн дагаврыг байраар нь ангилах /үгсийн аймгаар/

1.Судалгааны арга, хэрэглэгдэхүүн

Судалгааны аргын хувьд анхдагч болон хоёрдогч эх үүсвэрийг ашиглан, тоон судалгааны үндсэн аргаас толь бичгээс үг бүртгэж авах, чанарын судалгааны үндсэн аргаас судлаачийн зүгээс эх хэрэглэгдэхүүнээ боловсруулахдаа шинжлэх ухааны судалгааны үндсэн арга болох ажиглалт, анализ, синтезийн аргуудыг хослуулан хэрэглэж, хам цагийн үүднээс байдлыг тодорхойлж, тайлбарлах аргыг гол болголоо.

Судалгааны эх хэрэглэгдэхүүнд, Д. Уртнасан нар “Монгол хэлний их тайлбар толь” (2016 цахим хэлбэрээр), Я. Цэвэл “Монгол хэлний товч тайлбар толь”(2013) зэрэг толь бичгүүдийг ашиглахдаа хүний эерэг сэтгэл хөдлөлтэй холбоотой монгол хэлний нийт 177 үг хэллэгийг бүртгэн авч, үг бүтэх ёсных нь талаас тодрууллаа.

2.Судалгааны үр дүн

Үгийн язгуур, дагавар хоёр нийлж янз бүрийн үзэгдэл юмс, чанар, хөдөлгөөний дохио болж шинэ үг бүтээдэг учраас **үгийн сан-утга зүйтэй холбогдож**, дагавар нь үгийн бүтцэд урагшаа язгуур, хойшоо нөхцөлтэй харилцан шүтэлцэх байрлалд тохиолдох учраас үгийн бүтэц, бүтээвэр зүйтэй холбогддог байна (Өнөрбаян, 2000). Иймд бидний онцлон судалгаандаа авч үзэж буй үйл үг бүтэх аргын тухай судалгаа үгийн сан-утга зүйн судлалд зайлшгүй дурдагдах учиртай утга буюу агуулгын талыг тодорхойлж буй асуудал бөгөөд түүвэрлэн авсан үгсийн дийлэнх хувь нь үйл үг, тэр дундаа үүсмэл үйл үг учир гүн бүтцийг судлахын тулд өнгөн бүтцийн буюу хэлбэрийн талыг тодорхой хэмжээнд зохистой хослуулан судлах нь зүйтэй гэж үзсэн учир тусгайлан ажиглалт, судалгаа хийхийг чухалчлав. Ингэхдээ тухайн шинэ үг нь дагаврын аргаар үүсэхдээ үгийн сангийн ямар утга илэрхийлж буйг цухас дурдахыг зорилоо.

Үг бүтэх ёсны үндсэн нэгж болох үүсмэл үг нь бүтэц, бүтсэн аргынхаа талаар бүтээвэр зүй ба хэл зүйтэй, утга нэрлэлтийнхээ талаас үгийн сангийн судлал, утга зүйтэй холбогддог байна (Өнөрбаян, 2000). Иймд үүсмэл үг нь үг бүтэх ёсны үндсэн судлагдахуун бөгөөд үг бүтэх ёс нь монгол хэлний судлалд бие даасан салбар болон хөгжиж байна. Иймээс бид судалгаандаа хамруулсан нийт үйл үгийг үүсмэл үйл үгийн талаас нь ямар ямар дагаврын аргаар бүтсэн эсэх, тэдгээрийн утга, үүргийн талаар эх хэрэглэгдэхүүнд тулгуурлан тодорхойлов.

Мөн тус судалгаанд хамрагдсан үйл үг нь тоо хэмжээний хувьд цөөн учир зөвхөн **үүсмэл үйл үгийн хүрээнд авч үзлээ**. Түүнчлэн монгол хэлэнд үүсмэл биш үйл үг нь үүсмэл үйл үгээсээ харьцангуй цөөн байдаг аж.

Жишээлбэл: А. Лувсандэндэвийн “Монгол- Орос толь” (1957 он, 22000 орчим үгтэй), Я. Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь” (1966 он, 30000 үгтэй) зэрэгт тэмдэглэгдсэн үйл үгсийн дотор монгол хэлний үгийн бүтцийн хувьслын өнөөгийн түвшний үүднээс үзвэл дөнгөж 700 орчим үүсмэл биш (эдний дотор түүхэн үүднээс үзвэл үүсмэл үйл үг ч нэлээд байна) үйл үг байхад үүсмэл үйл үг хэдэн мянгаар тоологдож байна (Өнөрбаян, 2000).

Орчин цагийн монгол хэлний үг бүтэх ёсны тухай судалгааны бүтээл маш цөөн бөгөөд энэ талын голлох судалгаа хийсэн хүн бол эрдэмтэн Ц. Өнөрбаян юм. Иймээс уг эрдэмтний суурь судалгаанд тулгуурлан, үүсмэл үйл үгийн бүтсэн арга, утга, үүргийг тодорхойллоо.

Ц. Өнөрбаян “Орчин цагийн монгол хэлний үйл үг бүтэх ёс” (2000) бүтээлдээ: Үйл үг бүтээх нийт 36-н амьд дагавар байдаг талаар дурдаад, тэдгээрийн байр, утга, үүргийн талаар дэлгэрэнгүй тодорхойлсон байдаг.

Харин бидний судалгаанд 9 үйл үг бүтээх дагавар тохиолдож байсан ба тус дагаврын аргаар ямар ямар шинэ үг бүтсэн тухай судалгааны үр дүнгийн хэсэгт 3 хэсэгт авч үзсэн ба хүснэгтээр дэлгэрэнгүй үзүүлсэн болно.

1. Нэгдүгээр хэсэг. Баярлах сэтгэл хөдлөлтэй холбоотой монгол хэлний үйл үг бүтэх арга

Судалгаанд хамрагдсан “баярлах” сэтгэл хөдлөлтэй холбоотой монгол хэлний 43 үйл үг бүртгэгдсэн ба үүнээс 26 нь залгаврын аргаар буюу нийлэг аргаар бүтсэн үүсмэл үйл үг байв. Ингэхдээ үйл үг бүтээх “-ж, -л, -р, -с, -т -ш, -шаа” дагаврын аргаар сэтгэл хөдлөл илэрхийлсэн үүсмэл үйл үг үүсжээ.

Ер нь монгол хэлэнд нийлэг буюу залгаврын аргаар бүтсэн үүсмэл үйл үг түгээмэл байдаг талаар нэрт эрдэмтэн Ш. Лувсанвандан тодорхой үндэслэлтэй дүгнэлтүүдийг гаргасан байдаг. Харин үг хорших буюу задлаг аргаар бүтсэн үг цөөн тохиолдож байгаа нь монгол хэлэнд эл аргаар бүтсэн үйл үг тун ховор болохыг илтгэж байна. Жишээлбэл: *под хийх /шилж. Овоо, зэгсэн болох/, час хийх/час хийсэн дуу гаргах/, дав хийх /цочих/, жирс хийх /бие махбод агшин зуур цочирхийлэх/, уйлж унших, инээж ханиах* гэх мэт сэтгэл хөдлөл, хүний биед төрж буй таатай, таагүй мэдрэмж илэрхийлдэг задлаг аргаар бүтсэн үүсмэл үйл үг цөөн байдаг гэдгийг дурдах нь зүйтэй болов уу.

Залгаврын аргаар бүтсэн үүсмэл үйл үг нь хэрхэн үүсдэг талаар Я. Шмидтийн “Монгол хэлний зүй”(1831)-д үүсмэл үйл үг нь үйл үг, нэр үг, тэмдэг нэр, дайвар үг зэргээс үүснэ (79-80) гэж ангилан тус бүрд нь цөөн дагавар тэмдэглэснээс хойш өнөөдрийг хүртэл хэвлэгдсэн монгол хэлний зүйн бүх ном зохиол, сурах бичиг, судалгааны өгүүлэл зэрэгт (дурдсан дагаврын олон, цөөнийг эс тооцвол) дээрх ангиллыг үндсэнд нь баримталж байна. Өөрөөр хэлбэл, ихэнх судлаачид үйл үг бүтээх дагавруудыг байраар нь нэрээс үйл үг бүтээх, үйлээс үйл үг бүтээх, дайвар үгээс үйл үг бүтээх гэх мэтчилэн ангилж, тухайн дагавар тус бүрийн утга, үүргийн тухай дурддаг бөгөөд энэ талаар А. Д. Руднев, Ц. Ишдорж, Н. П. Поппе, В. Котвич зэрэг эрдэмтэд нарийвчлан судалсан байдаг.

Монгол хэлний “-ж- дагаврын аргаар бүтсэн үүсмэл үйл үг:

Монгол хэлний нэр язгуур, үндсээс эс тусах үйл үг бүтээх “-ж” дагаврыг анх А. Попов 1849 онд хэвлүүлсэн “Халимаг хэлний зүй” бүтээлдээ тэмдэглэсэн байдаг. Уг дагаврын аргаар тус бүлэгт *хөгжих, хөгжөөх, хөгжилдөх* зэрэг язгуур нэгтэй 3 үг бүртгэгдсэн байна.

Юмс үзэгдэл заасан нэр язгуур, үндсэнд “-ж-” дагавар залгаж язгуур, үндсээр тэмдэглэгдэж байгаа зүйл *өсөж төлжих, сайжран бэхжих* ба тухайн юмны шинжтэй болох утгатай үл тусах үйл үг бүтээнэ. Жишээлбэл: үр-үрж-, төл-төлж-, баян-баяж-, элбэг-элбэгж-, мөнгө-мөнгөж-, мал-малж-, чулуу-чулууж- гэх мэт (Өнөрбаян, 2000). Вл. Котвич, А. Д. Руднев, Ц. Ишдорж зэрэг эрдэмтэд –ж, -ш хоёрыг нэг дагаврын хувилбар хэмээн тэмдэглэсэн нь ч бий.

Монгол хэлний “-л” дагаврын аргаар бүтсэн үүсмэл үйл үг:

Хэл шинжлэлийн доктор (Ph. D) Ч. Соёлмаа “Монгол хэлний -ла, -л бүтээвэр” өгүүлэлдээ: Нэрээс үйл үг бүтээх дагаврын утгыг 1. Эзэмдэх утга /Жнь: ашигла, түшиглэ/; Уг юмаар үйлдэх утга /Жнь: товчил, жадал/; Үйлдэх бүтээх утга /Жнь: бүжиглэ, тусал/; багтаах, агуулах утга /Жнь: ханцуйл, сүвэгчил/; Эрэх хайх утга /Жнь: мэндэл, шинжил/; Өгөх утга /Жнь: бэлэглэ, оношил/; Салгах, ялгах утга /Жнь: дэллэ, хөөвөрлө/ гэх зэргээр утгын олон талаас нь ангилсан байдаг (Соёлмаа, 2013).

Тус судалгаанд хамаарагдах “-л” дагаврын аргаар бүтсэн үүсмэл үйл утгын талаас нь тайлбарлавал, *амраглах, баярлах, бодмоглох, инээмсэглэх, хүндлэх, хөөрцөглөх, өргөмжлөх* зэрэг үгс нь бүгд нэрээс үйл үг бүтээх “-л” дагаврын аргаар бүтсэн ба утгын хувьд эзэмдэх, өгөх гэсэн утга илтгэж байна.

Монгол хэлний “-р” дагаврын аргаар бүтсэн үүсмэл үйл үг:

Уг дагаврын аргаар *бадрах, бадруулах, биширэх, биширэгдэх, биширүүлэх, хөөрөх, хөөрцөглөх, хөхрөх* зэрэг цөөн тооны үг үүсжээ. Эдгээр үгс нь бүтэхдээ бад-, биш-, хөө- зэрэг идэвхгүй язгуураас дэврүүн санаа илэрхийлсэн үйл үндэс үүсгэсэн байна. Харин хөхрөх хэмээх үг нь хөх- гэсэн тэмдэг нэр буюу идэвхтэй язгуураас “-р” дагаврын аргаар үйл үндэс үүсжээ. Хөхрөх гэдэг нь үгийн сангийн утгын хувьд *инээх, их л тэсэж ядан хагдганаан инээх* гэсэн утга илтгэх ба ихэд хүч гаргаж инээх үед тухайн хүний нүүр царай нь хөх болон хувирдаг гэдэг үүднээс ийн шинэ үг үүссэн байж болно.

Энэхүү дагавар нь авианы нөлөөлөн хувьсах үзэгдлээс шалтгаалан үүссэн -р, -л гэсэн хоёр хувилбартай байдаг аж. Тухайлбал, 1рт: “-р-” хувилбарыг тухайн үгийн бүтцэд “р” гийгүүлэгчгүй бүхий л язгуур үндсэнд залгадаг байна. Жнь: сул-сулар-, жижиг-жижгэр- гэх мэт; 2рт: “-л-” хувилбарыг тухайн үгийн бүтцэд “р” гийгүүлэгчтэй язгуур үндсэнд залгана. Жнь: бор-борло-, шар-шарла- гэх мэт.

Монгол хэлний нэр язгуур, үндсээс үйл үг бүтээх “-р” дагаврыг судалгааны бүтээлдээ хамгийн анх 1835 онд Я. Шмидт тэмдэглэсэн байдаг ба үүнээс хойш О. Ковалевский, А. Попов, Ал. Бобровников, А. Орлов зэрэг гадаад дотоодын хэл шинжлэлийн олон эрдэмтэд сонирхон тэмдэглэсэн байдаг.

Монгол хэлний “-с” дагаврын аргаар бүтсэн үүсмэл үйл үг:

Тус бүлэгт “-с” дагаврын аргаар бүтсэн “баясах” хэмээх үг тохиолдож байгаа ба *баярлан хөгжих, хөөрөн баясах* гэсэн эерэг сэтгэл хөдлөл илэрхийлж байна.

Монгол хэлний эс тусах үйл үг бүтээх “-с” дагаврыг анх 1847 онд А. Попов тэмдэглэснээс хойш Г. И. Рамстедт, Т. А. Сабо, Б. Ринчен, Ш. Лувсанвандан зэрэг гадаад дотоодын нэрт эрдэмтэд өөрсдийн хэл зүйн бүтээлдээ тодорхой дурджээ.

Тус судалгаанд ердөө ганц л үг тохиолдсоноос ажиглавал уг дагавар тийм ч бүтээлч бус гэдгийг илтгэж байгаа юм.

Монгол хэлний “-т” дагаврын аргаар бүтсэн үүсмэл үйл үг:

Мөн нэрээс үйл үг бүтээх “-т” дагаврын аргаар бүтсэн “гэрэлтэх” гэсэн үг бидний бүртгэж авсан үгэнд тохиолдож байгаа ба утгын хувьд: *гэрэл гаргах, гэрэл тусгах* гэсэн ерөнхий утга илтгэж байна. Жнь: Оюутан залуучууд хэсэг хэсгээрээ зэл татан баярын царай гэрэлтүүлж баясгалангийн дуу уянгалуулан явна. С.Эрдэнэ. Хонгорзул., /МХИТТ/ Үгийн цөм утга нь “Гэрэл гаргах, гэгээ оруулах” гэсэн бодит утга илэрхийлж байгаа бол, үгийн шилжмэл утга нь тухайн хүний эерэг сэтгэл хөдлөлийг илэрхийлэхэд хийсвэр утгын үүрэгтэй байна. Гэрэл нь гэгээ оруулж, эргэн тойрноо гэрэлтүүлдэг гэдэг бодит утгад дулдуйдан, хийсвэр утгыг юмшуулж, сэтгэлд гэрэл гэгээ орох гэсэн санааг илэрхийлжээ.

Монгол хэлний “-ш” дагаврын аргаар бүтсэн үүсмэл үйл үг:

“Ш” дагаврын аргаар “урамших” гэсэн үйл үг үүссэн бөгөөд уг дагаврын талаар анх 1847 онд А. Попов бие даасан дагавар хэмээн тэмдэглэсэн байдаг.

Юм үзэгдэл, шинж чанар заасан нэр язгуур, үндсэнд -ш- дагавар залгаж тухайн юм үзэгдэл, шинж чанар бүхий болж хэвшин тогтох утгатай үл тусах үйл үг бүтэнэ. Жишээлбэл, бороо-бороош-, суурь-суурьш-, зан-занш-, хэв-хэвш-, хэврэг-хэврэгш-, шарх-шархаш-, уур-уурш- гэх мэт (Өнөрбаян, 2000). Монгол хэл шинжлэлийн зарим эрдэмтэд үйл үг бүтээх -ж, -ш хоёрыг нэг дагаврын хувилбар гэж үзэх нь ч бий. Тухайлбал, элбэгж-/ элбэгш, мэргэж-/мэргэш-, зунж-/зунш- гэх мэт.

Харин энэ талаар эрдэмтэн Ц. Өнөрбаян: цөөн үгэнд сэлгэж хэрэглэх боловч -ж, -ш хоёр нь бие биеийнхээ байранд тохиолдохгүй, утга, үүргээрээ ч тодорхой ялгарна гэж тодорхойлжээ. Ер нь “-ш” дагавар нь бусад үйл үг бүтээх дагавруудтай харьцуулахад тийм ч бүтээлч биш дагавар болох нь шинэ үг үүссэн цөөн хэдэн жишээнээс дүгнэж болох юм.

Монгол хэлний “-шаа” дагаврын аргаар бүтсэн үүсмэл үйл үг:

Судалгааны эл хэсэгт “сайшаах, мишээх, таашаах” хэмээх үг тохиолдож байна. Эдгээрээс жишээлэн тайлбарлавал, сайн гэсэн тэмдэг нэр буюу идэвхтэй язгуур болон “-шаа” хэмээх нийлмэл дагаврын аргаар *сайшаан дэмжих, магтах* гэсэн утга бүхий үйл үг үүсжээ. Харин “таа-” хэмээх идэвхгүй язгуураас “-шаа” гэсэн дагаврын аргаар сэтгэлд *нийцэх, ойшоох, тоомсорлон хүлээн авах* гэсэн утгалбар бүхий үүсмэл үйл үг үүссэн байна.

Эрдэмтэн Ц. Өнөрбаян “-шаа” дагавар нь үйл үг бүтээх дагаврууд дотроос хамгийн бүтээлч биш дагавар ба орчин цагийн монгол хэлэнд уг дагавартай нийт 10 гаруй үйл үг байдаг хэмээн дурджээ. Тухайлбал, *төвөгшөө, бэрхшээ, олшоо, амтшаа, өршөө, эрхшээ, дуриаа, адилаа, муушаа, буруушаа* гэх мэт.

Энэ дагаврыг анх А. Попов 1847 онд хэвлүүлсэн “Халимаг хэлний зүй”-дээ бие даасан дагавар (124-125) гэж дурдсанаас хойш Ал. Бобровников (1849, 212), Ю. Буденц (1887, 291), Вл. Котвич (1902, 91), А. Д. Руднев (1905, 36), Г. И. Рамстедт (1912, 75-76), М. Ишдорж (1930, 62), Н. Н. Поппе (1937, 79; 1954, 65), Т. А. Сабо (1943, 42), Б. Х. Тодоева (1951, 97), Ш. Лувсанвандан (1961, 288), Г. Д. Санжеев (ГБЯ., 1962, 178-179, 1964б, 57), Ж. Стрит (1963, 86), Ж. Ш. Дондуков (1964, 141-142), Б. Базылхан (ОЦМХ., 1966, 133), П. Бямбасан (1977, 6), П. Ц. Биткеев (1979, 77-78), Хас-Эрдэнэ (1982, 367) зэрэг судлагчдын бичсэн хэлзүйн ном зохиол, сурах бичиг, судалгааны өгүүлэлд тэмдэглэсэн боловч түүний байр, утга, үүргийг нэг мөр болгон тодорхойлоогүй байна (Өнөрбаян, 2000).

Уг дагаврын тухайд дүгнэж хэлбэл, цаашид монгол бичгийн хэлнээс нь мөшгөн судалбал, сонирхолтой ажиглалт, дүгнэлт гарч болох юм.

2. Хоёрдугаар хэсэг. Тэсвэр гэвчээртэй байх сэтгэл хөдлөлтэй холбоотой монгол хэлний үйл үг бүтэх арга

Тус судалгааны эл хэсэгт нийт 37 үг тохиолдож байна. Үүнээс үйл үг бүтээх

“-д, -ж, -л, -р, -рх, -с, -ш” дагаврын аргаар сэтгэл хөдлөл илэрхийлсэн нийт 29 үүсмэл үйл үг үүсжээ.

Монгол хэлний “-д” дагаврын аргаар бүтсэн үүсмэл үйл үг:

Тус судалгаанд нэрээс үйл үг бүтээх “-д” дагаврын аргаар “*бахдах, найдах*” гэсэн үг үүссэн ба бахдах хэмээх үг нь үгийн сангийн утгын хувьд: *сэтгэл ханан баясаж, хөөр бах болох* утга илтгэж байна. Жнь: Амбасын яамны үүдэнд улс амьтан овооролдон цуглаад их л номхон дүртэй болсон манж ноёд эздээ орон сууцнаас нь зайлуулж байгааг бахдан харжээ. Б. Ринчен. Үүрийн туяа /МХИТТ/ Мөн бахдах хэмээх үгийн “бах-” нэр язгуурыг *бах тав* хэмээн үг хорших, *бах нь ханах* туслах үйл үгтэй хамт хэрэглэхдээ сөрөг сэтгэл хөдлөл илэрхийлсэн утга заадаг.

Харин *найдах* гэдэг үг нь “най-” гэсэн идэвхгүй язгуураас үйл үг бүтээх -д дагаврын аргаар бүтсэн ба *бусдын үг, хүчинд итгэх, итгэл хүлээлгэх* гэсэн үгийн сангийн утга илэрхийлж байна /МХИТТ/.

Монгол хэлний “-ж-” дагаврын аргаар бүтсэн үүсмэл үйл үг:

“-Ж” дагаврын аргаар *зоригжих* гэсэн үг бүртгэгдсэн байна. Уг үг нь зориг улам нэмэгдэх, зориг орох гэсэн үгийн сангийн утгатай. /Үйл үг бүтээх “-ж” дагаврын талаарх дэлгэрэнгүйг 1-р хэсгээс үзнэ үү./

Монгол хэлний “-л” дагаврын аргаар бүтсэн үүсмэл үйл үг:

“-Л” дагаврын аргаар бүтсэн үүсмэл үйл үг *авхаалжлах, баазлах, баатарлах, дурлах, дурлуулах, дээдлэх, дээдлүүлэх, зориглох, зүрхлэх, шаламгайлах, эрэмгийлэх* гэх мэт цөөнгүй үг тохиолдож буй нь “-л” дагаврын бүтээлч шинжтэй нь холбоотой гэж ойлгож болох юм. /Үйл үг бүтээх “-л” дагаврын талаарх дэлгэрэнгүйг 1-р хэсгээс үзнэ үү./

Монгол хэлний “-р” дагаврын аргаар бүтсэн үүсмэл үйл үг:

Уг дагаврын аргаар эл хэсэгт *ажаарах, сэргэх, сэргээх, шагширах* цөөн үг тохиолдож байна. Эдгээр үгсийн үгийн сангийн утгыг хавсралт хэсгийн хүснэгтээс үзэж болно. /Үйл үг бүтээх “-р” дагаврын талаарх дэлгэрэнгүйг 1-р хэсгээс үзнэ үү./

Монгол хэлний “-рх” дагаврын аргаар бүтсэн үүсмэл үйл үг:

Энэ дагаврыг анх 1847 онд А. Попов бие даасан дагавар гэж тэмдэглэснээс хойш Вл. Котвич, А. Д. Руднев, Г. И. Рамстедт, Ц. Ишдорж, Б. Ринчен, Ш. Лувсанвандан зэрэг гадаад дотоодын олон эрдэмтэд сонирхон тэмдэглэжээ.

Тус бүлэгт *бахарх, шохоорх* гэсэн хоёр үг тохиолдож байна. Бах- идэвхтэй нэр язгуураас -рх үйл үг бүтээх дагаврын аргаар *сэтгэлд хавтай, бахтай, баясах, бишрэн бахархах, гайхан бахархах* гэсэн утга бүхий шинэ үйл үг үүссэн байна. Харин шохоорх гэдэг үг нь шохоо- хэмээх идэвхгүй язгуураас -рх гэсэн дагаврын аргаар *ихэд сонирхох, хүсэх, шохоорхон харах* гэсэн үгийн сангий утга бүхий үйл үг тус тус үүсжээ.

Жинхэнэ нэр, тэмдэг нэр үндсэнд Мо. б.: -rqa rke Мон Бур.-рх гха -гхе Хал:-рх дагавар залгаж тэр зүйлээр бахдаж бардах, давамгайлах утгатай үйл үүсгэнэ (Г. Гантогтох, 1983) гэжээ. Үүнээс үзвэл, “-рх” дагавар нь ихэнхдээ *ээрх, ахарх, баярх, сайрх, ноёрх, яларх* гэх мэтчилэн хүний ааг, омог, давамгай байдлыг илтгэх ба хүний сөрөг сэтгэл хөдлөл илэрхийлсэн үг бүтээх үүрэгтэй гэж дүгнэж болохоор байна. Өөрөөр хэлбэл, -рх дагавар нь гол төлөв сөрөг утга илтгэдэг учир бидний бүртгэж авсан хүний эерэг сэтгэл хөдлөл илэрхийлсэн үгэнд ердөө “*бахархах, шохоорхох*” гэсэн хоёр үг тохиолдож буйгаас харж болох юм.

Монгол хэлний “-с” дагаврын аргаар бүтсэн үүсмэл үйл үг:

Судалгааны эл хэсэгт “-с” дагаврын аргаар бүтсэн *дурсах, дурсагдах, дуурсагдах* гэсэн язгуур нэгтэй 3 үг бүртгэгджээ. Эдгээр үгсийн язгуурын утга нь *эргэн бодох, сэргээн ярих, эргэн санагдах, нэхэж бодогдох* гэсэн үгийн сангийн ерөнхий утгыг илтгэж байна. /Үйл үг бүтээх “-с” дагаврын талаарх дэлгэрэнгүйг 1-р хэсгээс үзнэ үү./

Монгол хэлний “-ш” дагаврын аргаар бүтсэн үүсмэл үйл үг:

Мөн “-ш” дагаврын аргаар бүтсэн “*ээнэгиших*” гэсэн нэг үг тохиолдож байгаа бөгөөд уг үг нь хүмүүс бие биедээ дасах, ойр дотно болох гэсэн үйл байдлыг илтгэж байна. /Үйл үг бүтээх “-ш” дагаврын талаарх дэлгэрэнгүйг 1-р хэсгээс үзнэ үү/

3. Гуравдугаар хэсэг. Тайван байх сэтгэл хөдлөлтэй холбоотой монгол хэлний үйл үг бүтэх арга

“Тайван байх” сэтгэл хөдлөлтэй холбоотой монгол хэлний үйл үг нь нийт 43 бүртгэгдсэн байна. Үүнээс үйл үг бүтээх “-ж, -л, -р, -с, -т” зэрэг 5 дагаврын аргаар нийт 33 үүсмэл үйл үг үүсжээ.

Монгол хэлний “-ж- дагаврын аргаар бүтсэн үүсмэл үйл үг:

“*-Ж*” дагаврын аргаар бүтсэн *амаржих*, гэсэн үг байна. Уг үгс нь *амаржин жаргах, амар тайван болгох* гэсэн үгийн сангийн утга илэрхийлж байна. /Үйл үг бүтээх “-ж” дагаврын талаарх дэлгэрэнгүйг 1-р хэсгээс үзнэ үү/

Монгол хэлний “-л” дагаврын аргаар бүтсэн үүсмэл үйл үг:

“*-Л*” дагаврын аргаар *аажимлах, амарлих, анирлах, агуучлах, бодмоглох, хайлах, хайрлах, энхрэглэх, энхрийлэх, янаглах* зэрэг цөөнгүй үг үүссэн нь үйл үг бүтээх -л дагаврын бүтээлч шинжтэй нь холбоотой юм. /Үйл үг бүтээх “-л” дагаврын талаарх дэлгэрэнгүйг 1-р хэсгээс үзнэ үү/

Дээрх үйл үгсийн *аажимлах, амарлих, агуучлах, энхрэглэх, энхрийлэх* зэрэг нь тэмдэг нэрээс үүссэн ба хайрлах гэдэг үг нь жинхэнэ нэрээс үүссэн бол *янаглах* нь тэмдэг нэр болон жинхэнэ нэрийн дундын шинжтэй байна. Тодруулбал, ТЭН-ийн утга нь: хамгийн дотно хайртай, ЖН-ийн утга нь: амраг, янаг амраг хорш /МХИТТ/ гэх мэт.

Харин “*агуучлах*” гэдэг үгийн үгийн сангийн утга нь *агууч сэтгэл гаргах, агууч байх* гэсэн утга илтгэж байгаа ба орчин цагийн монгол хэлний “уучлах” хэмээх үгийн язгуур утга юм. “Агууч-ууч” гэсэн хоёр үг нь авиа зүйн хувьд дундад зууны үеийн монгол хэлний урт эгшгийн хувьсалтай холбоотой үүссэн хувилбар байж болох юм.

Монгол хэлний “-р” дагаврын аргаар бүтсэн үүсмэл үйл үг:

Судалгааны эл хэсэгт “-р” дагаврын аргаар *аажуурах, амрах, дөлгөөрөх, нялуурах, тайвирах, тайтгарах, талбиурах, уужрах, уужирсхийх, уярах, уяраах, элбэрэх, энэрэх* зэрэг цөөнгүй үг тохиолдож байна. Үүнээс дүгнэвэл, үйл үг бүтээх “-р” дагавар нь шинэ үг бүтээх тал дээр “-л” дагаврын адил нэлээд бүтээлч дагавар гэдэг ажиглагдаж байна. Онцлон дурдахад, дээрх үүсмэл үйл үгийн ихэнх нь *аажуу, амар, дөлгөөн, тайван, талбиун, уужуу* зэрэг хүний шинж чанар заасан тэмдэг нэрээс үүсжээ. /Үйл үг бүтээх “-р” дагаврын талаарх дэлгэрэнгүйг 1-р хэсгээс үзнэ үү/

Монгол хэлний “-с” дагаврын аргаар бүтсэн үүсмэл үйл үг:

Тус хэсэгт “-с” дагаврын аргаар *дасах, дотносох, нигүүлсэх, нялхамсах, эвсэх, эвсэлдэх* гэсэн үүсмэл үйл үг үүсжээ. /Үйл үг бүтээх “-р” дагаврын талаарх дэлгэрэнгүйг 1-р хэсгээс үзнэ үү/

Монгол хэлний “-т” дагаврын аргаар бүтсэн үүсмэл үйл үг:

“-Т” дагаврын аргаар “амгалантах” гэсэн үг бүтсэн ба мөн “амгаландах” хэмээн авиа зүйн хувьд шуугиант, хамжих “д, т” авиабарууд харилцан сэлгэх авиа зүйн үзэгдлээс үүссэн хоёр хувилбар хэдий ч утгын хувьд ижил юм. /Үйл үг бүтээх “-т” дагаврын талаарх дэлгэрэнгүйг 1-р хэсгээс үзнэ үү/

Монгол хэлний дээрх дагавруудаас “-л”, “-р” дагавар нь бусад үг бүтээх дагавартай харьцуулахад нэлээн бүтээлч шинжтэй байсан ба эерэг сэтгэл хөдлөл илэрхийлсэн цөөнгүй шинэ үг бүтжээ. Жнь: “-р” дагаврын аргаар *аажуурах, аажимлах, амгаландах, амгалантах, амарлих, амаржих, амрах, агуучлах, дотносох, дөлгөөрөх, наалинхайрах, нялуурах, нялхамсах, тайвшрах, тайтгарах, талбиурах, тэнийх(тэнүүн), уужрах, уужирсхийх, уярах(уян), уяраах, энхрэглэх, энхрийлэх, ээнэгших* гэх мэт нэлээд үг үүсжээ.

Монгол хэлний эерэг сэтгэл хөдлөл илэрхийлсэн үйл үгийн орны ангилал

Хүснэгт 1.

Үйл үгийн орон	Баярлах (1)	Тэсвэр тэвчээртэй байх (2)	Тайван байх (3)
Биеийн үйлдэл хавсран илрэх	Амраглах, баясах, малийх, мишээх, инээх, инээмсэглэх, инээвхийлэх, хөөрцөглөх, хөгжөөх, хөхрөх, цэнгэх, өргөмжлөх	Баазлах, баатарлах, найзархах, авхаалжлах, гялалзах, шаламгайлах, наалинхайрах,	Эвсэх, эвсэлдэх, эелдэгдэх, янаглах, аажуурах, аажимлах, дотносох, дөлгөөрөх, нялуурах, нялхамсах, уужирсхийх, уяраах, энхрэглэх, энхрийлэх, налайх, түших, шохоорхох, элбэрэх,
Сэтгэл хөдлөлөөр илрэх	Баярлах, бадрах, бадруулах, хөөрөх, хөгжих, урамших, элгэмсэх, сонирхох, гайхах, гялайх, гялайлгах, гэрэлтэх, додийх, таашаах	Ажаарах, болгоох, дурлах, дурлуулах, дурсах, дурсагдах, найдах, зоригжих, зориглох, зүрхлэх, итгэх, илтгэлцэх, иршүүлэх, дээдлэх, дээдлүүлэх, зөвшөөх, сэргэх, сэргээх, эрэмгийлэх,	Анирлах, бодмоглох, санагалзах, өрөвдөх, хайрлах, амгаландах, амгалантах, амарлих, амаржих, амрах, агуучлах, тайвшрах, тайтгарах, талбиурах, тэнийх, уужрах, уярах, ээнэгших, дасах, жаргах, ханах, хайлах, нигүүлсэх, хайрлах, энэрэх
Хэлээр илрэх	Бахдах, магтах, талархах, сайшаах, бишрэх	Шагшрах	Дуурьсагдах

Хүснэгт 1. дэх ангиллыг харахад хэдийгээр эерэг сэтгэл хөдлөл илэрхийлсэн үгсийн ихэнх нь сэтгэлээр үйлдэх оронд харьяалагддаг ч, хүн дотоод сэтгэл хөдлөлөө гаргахдаа биеийн хэлэмж, үг хэлээр илэрхийлэх нь түгээмэл учир биеэр үйлдэх болон, хэлээр үйлдэх оронд ч цөөнгүй үг хамаарагдаж байна. Өөрөөр хэлбэл, сэтгэлд төрсөн эерэг мэдрэмж нь давхар биеийн хэлэмж болон үг хэлтэй хамсаж, харилцагч этгээдэд өөрийн төрөгдлийг илүү тодорхой илэрхийлэх боломжтой.

Нэг ёсондоо эерэг сэтгэл хөдлөл илэрхийлсэн үг хэллэгийг биеийн үйл хөдлөл, үг хэлнээс ангид хэмээн ойлгож, зөвхөн сэтгэлээр үйлдэх хүрээний үгсийг хамааруулж авч үзэх нь өрөөсгөл ойлголт юм.

ДҮГНЭЛТ

Үг бүтэх ёсны талаарх дүгнэлт:

Дан үг: Монгол хэлэнд дан үгээр илрэх сэтгэл хөдлөл илэрхийлсэн үйл үг тохиолдоггүй бөгөөд ихэнх үйл үг нь дагаврын аргаар бүтдэг байна.

Нийлмэл үг: Монгол хэлэнд хүний эерэг сэтгэл хөдлөл илэрхийлсэн нийлмэл үг түүвэрлэх явцад *нар гарах, сэтгэл хөдлөх, сэтгэл татагдах, бат нот имгэх* зэрэг маш цөөн тохиолдов. Харин “өрөвдөх” гэж үг нь *өр өвдөх* гэсэн хоёр үгийн нийлэмжээс буюу задлаг аргаар /үг нийлэх/ үүсжээ. Монгол хэлэнд эерэг сэтгэл хөдлөл илэрхийлсэн дан, нийлмэл бүтэцтэй үг маш цөөхөн байсан тул бид судалгааны ажилдаа тусгайлан авч үзээгүй бөгөөд дүгнэлт хэсэгт товч дурдсан болно.

Үүсмэл үг: Тус судалгаанд орсон монгол хэлний нийт үгний 88 нь дагаврын аргаар үүсмэл үйл үг бүтээжээ. Үүнд: “-д, -ж, -л, -р, -рх, -с, -т, -ш, -шаа” зэрэг 9 дагавар бүртгэгдсэн байна. Эдгээрээс хамгийн бүтээлч нь “-л”, “-р” гэсэн дагавар гэдгийг уг судалгаа давхар баталж байв.

Жишээлбэл: “-л” дагаврын аргаар **Баярлах сэтгэл хөдлөл илэрхийлсэн үгийн бүрэлдэхүүнд** *амраглах, баярлах, бодмоглох, инээмсэглэх, хүндлэх, хөөрцөглөх, өргөмжлөх; Тэсвэр тэвчээртэй байх сэтгэл хөдлөл илэрхийлсэн үгэнд* *авхаалжлах, баазлах, баатарлах, дурлах, дурлуулах, дээдлэх, дээдлүүлэх, зориглох, зүрхлэх, шаламгайлах, эрэмгийлэх; Тайван байх сэтгэл хөдлөл илэрхийлсэн үгэнд* *аамжимлах, амарлих, анирлах, ангуучлах, бодмоглох, хайлах, хайрлах, энхрээглэх, энхрийлэх, янаглах* зэрэг цөөнгүй үүсмэл үйл үг бүтжээ. /Дэлгэрэнгүйг хавсралт 1.-ээс үзнэ үү./

Үгсийн аймгийн талаарх дүгнэлт: Хэл шинжлэлийн эрдэмтэн А. Д. Руднев, Н. П. Поппе нар үйл үг бүтээх дагавруудыг байраар нь нэрээс үйл үг бүтээх, үйлээс үйл үг бүтээх, дайвар үгээс үйл үг бүтээх гэх мэтчилэн ангилсан байдаг.

Харин бид бүртгэж авсан эерэг сэтгэл хөдлөл илэрхийлсэн монгол хэлний нийт 117 үгсийн 88 үйл үгийг үйл үг бүтээх дагаврын байраар нь ангилахдаа нэр үгийг дотор нь задлан, жинхэнэ нэрээс үйл үг бүтэх, тэмдэг нэрээс үйл үг бүтэх, үйл үгээс үйл үг бүтэх гэх зэргээр ангилав. Тухайлбал,

Монгол хэлэнд: Жинхэнэ нэр, тэмдэг нэр, үйл үгийн язгуураас тус бүр хэдий хэмжээний үг бүтсэн эсэхийг хүснэгтээр гаргахад, ЖН-34, ТЭН-37, ҮҮ-46 тус тус бүртгэгдсэн байна. Үүнээс дүгнэвэл, жинхэнэ нэр, тэмдэг нэр, үйл үгийн аль алинаас сэтгэл хөдлөл илэрхийлсэн үйл бүтэх зүй тогтол болон тоо хэмжээний хувьд ойролцоо байна. Өөрөөр хэлбэл, эдгээр үгсийн айн аль аль нь шинэ үг бүтээхдээ идэвхтэй байгааг тус судалгаанаас харж болно. /Дэлгэрэнгүйг хавсралт 2.-оос үзнэ үү./

Хэдийгээр үг бүтэх ёсны тухай дээрх судалгаа нь хэл шинжлэлийн ач холбогдолтой боловч нөгөө талаар өнөөгийн нийгмийн хүмүүс хоорондын харилцаанд илэрч буй үгийн сонголт, тэр дундаа залуусын хэл яриа, үгийн баялаг муудаж байгаатай холбоотойгоор монгол хэлэнд дагаврын аргаар маш олон үг бүтэх зүй тогтолтой байдгийг ухаарч, эдгээр үгсийг өдөр тутмын харилцаандаа хэрэглэж хэвших нь эх хэлний дархлаанд чухал ач холбогдолтойгоос гадна хэлний багш нар үгийн язгуур, үүр нэгтэй үгсийн бүтэх аргыг судалж, суралцагчдад тайлбарлан таниулахад үүрэгтэй.

Түүнчлэн энэ чиглэлийн судалгаа АНУ, япон, солонгос зэрэг оронд өргөн хүрээнд судлагдсан ч монголд сонирхон судалсан нь тун ховор байгаа ба цаашид хэл шинжлэлийн судлагдахууны хувьд шинэ чиглэл болон хөгжиж, судалгааны эргэлтэд ороход чухал үүрэг гүйцэтгэх нь дамжиггүй.

Тодруулбал, эерэг сэтгэл хөдлөл илэрхийлсэн үгийг үг бүтэх ёс, үгсийн сан, утга судлал, танихуйн хэл шинжлэл болон нийгэм хэл шинжлэл зэрэг хэл шинжлэлийн салбар судлагдахууны зааг дээр шинжлэх боломж байгааг онцлон дурдаж байна.

Note: Товчилсон үгийн тайлбар

МХИТТ-Монгол хэлний их тайлбар толь

ЖН- жинхэнэ нэр

ТэН-тэмдэг нэр

ҮҮ-үйл үг

Мо.б-монгол бичиг

A Study on Derived Verbs Expressing Positive Emotions in the Mongolian Language

Lkhagvabayar Khulan 

Ph.D, Department of General Education, “Mongol Kosen” College of
Technology, Ulaanbaatar, Mongolia

Abstract: This study investigates the morphological structures of 117 Mongolian verbs denoting emotional states—specifically those expressing “Happiness,” “Perseverance,” and “Calmness.” —as documented in The Great Dictionary of the Mongolian Language (2016). The research aims to classify and analyze the derivational patterns of these emotion-related verbs based on their morphological formation and suffixal affixation, grounded in linguistic theory. The research is structured into three primary sections: 1. Derivational patterns of verbs associated with Happiness emotions; 2. Derivational patterns of verbs related to the expression of patience; 3. Derivational patterns of verbs expressing a calm emotional state. The study emphasizes that the lexical inventory of any language is intricately linked to the cultural, psychological, and social characteristics of its speakers. In this context, emotion-expressing verbs in Mongolian are analyzed through a linguistic lens, with a focus on their grammatical categories, derivational mechanisms, and semantic domains. Among the 117 verbs surveyed, 88 were found to be formed through suffixation. A total of nine suffixes were identified—namely -d, -j, -l, -r, -rkh, -s, -t, -ts, and -shaa—with -l and -r being the most frequently occurring. These suffixes demonstrate productive morphological processes in the formation of emotion-related verbs. The findings of this study are significant for deepening the understanding of Mongolian verb morphology and hold practical implications for language instruction, particularly in elucidating the etymology, structure, and semantic function of derived verbs to language learners.

Keywords: *Vocabulary, Principles of word formation, neologism, Language use*

НОМ ЗҮЙ

Hart.W. (2013). Unlocking past emotion: Verb use affects mood and happiness. *Psychological Science*, 19-26. <https://doi.org/10.1177/0956797612446351>

Pexman, E. M. (2024). The role of emotion in acquisition of verb meaning Cognition and Emotion. *Cognition and Emotion* , 491-508. <https://doi.org/10.1080/02699931.2024.2349284>

Ариунчимэг. (2023). *Хүний эерэг сэтгэл хөдлөлтэй холбоотой солонгос, монгол үг хэллэгийн утгын харьцуулсан судалгаа*. Улаанбаатар: Олон Улсын Улаанбаатарын Их сургууль.

Бадамдорж. Д. (2021). Монгол хэлний бүрэлдүүлбэр судлал. УБ.

Гантогтох, Г. Лувсанбалдан.Х. (1985). Монгол хэлнүүдийн харьцуулсан хэл зүй. УБ: ШУА-ийн ХЗХ.

Өнөрбаян, Ц. (2000). *Орчин цагийн монгол хэлний үйл үг бүтэх ёс*. Улаанбаатар.

Санжжав. Д. (1999). Сэтгэл судлал. УБ.

Соёлмаа, Ч. (2013). Монгол хэлний "-ла", "л" бүтээвэр. *Монгол судлалын чуулган*. МУБИС-ийн МоСС-ийн ЭШ-ний сэтгүүл. №15(50). Улаанбаатар

Төмөрцэрэн. Ж. (1974). Монгол хэлний үгийн сангийн судлал. УБ.

Уртнасан нар. Д. (2016). Монгол хэлний их тайлбар толь. УБ.

Цэвэл. Я. (1966, 2013). Монгол хэлний товч тайлбар толь. УБ.

**ХАВСРАЛТ 1. Эерэг сэтгэл хөдлөл илэрхийлсэн үйл үгийн бүтэх арга /Хүснэгтээр/
 (Дагаврын аргаар бүтсэн үүсмэл үйл үг)**

Үйл үг бүтээх дагаврууд	Шинэ үг бүтсэн тоо	Баярлах (1)	Хүчтэй байх (2)	Тайван байх (3)
-д-	(1):0 (2):2 (3):1	-	бахдах, найдах	амгаландах
-ж-	(1):3 (2):1 (3):1	хөгжих, хөгжөөх, хөгжилдөх	зоригжих	амаржих
-л-	(1):8 (2):11 (3):10	амраглах, баярлах, бодмоглох, инээмсэглэх, инээвхийлэх, хүндлэх, хөөрцөглөх, өргөмжлөх	авхаалжлах, баазлах, баатарлах, дурлах, дурлуулах, дээдлэх, дээдлүүлэх, зориглох, зүрхлэх, шаламгайлах, эрэмгийлэх	аажимлах, амарлих, анирлах, ангуучлах, бодмоглох, хайлах, хайрлах, энхрэглэх, энхрийлэх, янаглах
-р-	(1):5 (2):6 (3):14	бадрах, бишрэх, хөөрөх, хөөрцөглөх, хөхрөх	наалинхайрах, сэргэх, сэргээх, шагшрах, элбэрэх, энэрэх	Ажаарах, аажуурах, амрах, дөлгөөрөх, нялуурах, тайвшрах, тайтгарах, талбиурах, уужрах,уужирсхийх, уярах, уяраах, элбэрэх, энэрэх
-рх-	(1):2 (2):3 (3):0	сонирхох, талархах	бахарх, найзархах, шохоорх	-
-с-	(1):1 (2):5 (3):6	баясах	дасах, дотносох, дурсах, дурсагдах, дуурьсагдах	дасах, дотносох, нигүүлсэх, нялхамсах, эвсэх, эвсэлдэх
-т-	(1):1 (2):0 (3):1	гэрэлтэх	-	амгалантах
-ш-	(1):1 (2):1 (3):1	урамших	ээнэгших	иршүүлэх
-шаа-	(1):3 (2):0 (3):1	сайшаах, мишээх, таашаах	-	зөвшөөх
Нийт дүн		26	29	33
9	88			

ХАВСРАЛТ 2.

Эерэг сэтгэл хөдлөл илэрхийлсэн үг хэллэгийн үгсийн аймгийн ангилал /Хүснэгтээр/

Үгсийн аймаг	Баярлах (1)	Хүчтэй байх(2)	Тайван байх(3)	Нийт
Жинхэнэ нэрийн язгуураас бүтсэн үгс	амраглах, бахархах, бахдах, баярлах, гэрэлтэх, хүндлэх, хөөрөх, хөөрцөглөх, хөгжих, хөгжөөх, хөгжилдөх, талархах, урамших, элгэмсэх	анирлах, найзархах, санагалзах, өрөвдөх, хайрлах, эвсэх, эвсэлдэх, эелдэгдэх, янаглах	баазлах, баатарлах, дурлах, дурлуулах, дурсах, дурсагдах, дуурьсагдах, зоригжих, зориглох, зүрхлэх, иршүүлэх	(1):14 (2):9 (3):11
Тэмдэг нэрийн язгуураас бүтсэн үгс	Сайшаах, сонирхох, хөхрөх	шаламгайрах, эрэмгийлэх	аажуурах, аажимлах, амгаландах, амгалантах, амарлих, амаржих, амрах, агуучлах, дотносох, дөлгөөрөх, авхаалжлах, бахдууштай, гялалзах, нигүүлсэх, наалинхайрах, нялуурах, нялхамсах, тайвшрах, тайтгарах, талбиурах, тэнийх(тэнүүн), уужрах, уужирсхийх, уярах(уян), уяраах, дотносох, дээдлэх, дээдлүүлэх, зөвшөөх, энхрэглэх, энхрийлэх, ээнэгших	(1):3 (2):2 (3):32
Үйл үгийн язгуураас бүтсэн үгс	Бадрах, бадруулах, баясах, бишрэх, бишрэгдэх, бишрүүлэх, гайхах, гийх, гялайх, гялайлгах, додийх, инээх, инээмсэглэх, инээвхийлэх, магтах, магтуулах, малийх, мишээх, цэнгэх, хөөрөх, хөөрцөглөх, өргөмжлөх, таашаах	бодмоглох, дасах, жаргах налайх, ханах, хайлах, шагшрах, шохоорхох, элбэрэх, энэрэх	ажаарах, болгоох, гялайх, дасах, итгэх, итгэлцэх, итгэмхий, сэргэх, сэргээх, түших, найдах, энэрэх, элбэрэх	(1):23 (2):10 (3):13
Нийт дүн: 117				ЖН-34 ТЭН-37 ҮҮ-46